

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Амбаагийн Түнаадай	Дугаар	L042
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Өвөрхангай аймаг	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Арвайхээрийн Зүүн хүрээ,	Сүм хийдийн дугаар	ӨХАХ 041
Одоогийн сүм хийд	Ламрим хийд	Сүм хийдийн дугаар	UB 04
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Зүүн хүрээ одоогийн Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт Хүнхэрийн гол гэдэг газарт байсан. Ноён уул, Гурван залаат, Хайрхан зэрэг тахилгатай уул нуруу эргэн тойронд нь байдаг байсан. Хийдийг Зүүн хурал, Зүүн хүрээ гэж нэрлэдэг. Өөр төвд нэр байхгүй.

Зүүн хурал 1670 хэдэн онд байгуулагдсан гэж ярьдаг байсан. Агь гүний хошууны ноёд нийлж байгуулсан гэдэг.

Зүүн хүрээний гол шүтээн нь Лхам, ядам нь Чойжоо. 200-300 гаруй ламтай, 8 дацантай хийд байсан. Цогчэн, Чойр, Манлын, Ламан чодвын, Нүгнээний, Жүншгийн, Сахиусны, Хайлангийн, Хайлан жасын гэсэн дуганууд байсан.

Зүүн хуралд шавилан сууж байсан лам нар нь ихэвчлэн Агь гүний хошууных байсан.

Хийдэд хамба лам гэж байгаагүй. Ловон, цорж гэж байсан. Намайг байхад хийдийн ловон нь Сүнрэв, цорж нь миний ээжийн ах лам, Төвдөд 5 жил сурч дооромбо цол авсан Шинлэг дооромбо гэдэг хүн байсан. Манай ах лам хийд хаагдахаас хоёр жилийн өмнө нас барсан. Тэгээд цорж тавилгүй байж байгаад хаагдсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Унзад нь Ёндон унзад, Гандиваа унзад гэж байсан. Арай түрүүхэндээ Цэдэнцэв, Шийрав унзад гэж байсан. Гэсгүй нь олон солигдсон доо. Хамгийн сүүлд нь Дашчийрэв гэдэг хүн байж байсан. Сүнрэв ловон, Дашчийрэв гэсгүй хоёр хамгийн түрүүнд 1937 оны Цагаан сарын битүүний өдөр баригдаад явсан. Тэгээд л 1938 оны хавраас бариад эхэлсэн. Хэлмэгдлийн цагаан номонд Сүнрэв гавж, Дашчийрэв гавж хоёрын нэр орсон байгаа.

Хувилгаан гэсэн хүн манайд нэг их байгаагүй. Жамьянтүндэв гэдэг нэг их мэргэн, эрдэмтэй лам, Гүндай гэдэг нэг бурхан зурдаг хүн байсан. Төвд лам байгаагүй.

Би цогчэн, чойр дацангуудад хурж байсан.

Хийдийн хойд талд 6 суварга байсан. Би 5 жилийн өмнө тэр суваргануудын суурин дээр нэг суварга босгосон. Одоо тэнд миний нэртэй нэг суварга бий. Бүх дуганууд монгол маягийн модон дуган байсан. Тэр хойно байсан 6 суварганаас өөр юманд тоосго ороогүй. Манайд номын бар байгаагүй. Харин Баруун хүрээнд байсан. Арвайхээрийн Баруун хүрээ барт хүрээ гэж их бартай байсан юм.

Хурал номын хувьд одоогийнхтой яг адил. Нас барсан хүнд ерөөл ерөөж маанийн ерөөл уншина. Гүнрэг уншина. Хойтоход нь зориулж Буман дарь эх их хурдаг байсан. Гол цогчэн уншлага нь итгэл, дарь эхүүд уншина. Энд до дүдва, уманжүг, ондогжан 3-г цогчинд уншаад байх юм. Хуучин манайд бол энэ 3-г Чойрт л уншдаг байсан.

Төвдийн хийдтэй харилцаа холбоо байгаагүй. Төвд лам ч байгаагүй. Хүрээнд л төвд лам байсан гэж дуулддаг байсан. Манайхаас ганц нэг хүмүүс хувиараа Төвд рүү явж сурсан байх. Манай ээжийн ах лам Төвдөд 5 жил сураад ирсэн.

Чойрт хадаг, шидүв, ог, гом, дом, гээд 8 гавжтайгаа 9 болно. Гавжийн дамжаа барина. Айраг цагаа их элбэг үед л барьж байсан. Нэг барихдаа тэр зинзаанд хэдэн хүн байна тэр бүгд л барьдаг байсан. Домын дамжаа ч адил. Манай чойр Богд ламын игчаагаар явдаг байсан. Би дом тавиад л хар болсон. Манай зиндаа 50 гаруй ламтай байсан. Жорвон нь Авирмэд гэдэг хүн байсан. Анги данбо нь Пүлжин гэдэг хүн байсан. Би нэг дундад нь л явж байсан. Баруун хүрээнээс манай дээр дом тавих, гавжийн дамжаа барихад их ирдэг байсан. Мөн зуны хурлаар, үе үеийн хурлаар их ирдэг байсан. Жавданд багтахгүй араар нь суудаг байлаа. Тийм л харилцаатай байсан.

Хүрээ дэгтэй байсан. Чойр нь Гунгаачойлинтой адил дэгтэй байсан. Цагаан сараар Чонпрүлжона гэж дандаа ерөөл 15 хоног хурна. Өвлийн сүүл сарын 26, 27,28-нд Хангал хураад 29-нд сор зална. Битүүний өдөр үдээс өмнө жирийн хурлаа уншаад эртхэн гадаална. Цагаан сарын бэлтгэл гээд. Тэгээд орой нь үргэлжлүүлээд Цэдэр уншина. Шөнөжин уншаад маргааш өглөө нь нарнаар дуганын үүдэнд лам нартайгаа золгочихоод гэр гэртээ очдог байсан. Богд ламын дүйчэн өдрөөр Богд ламын чого уншдаг.

Цам гардаггүй байсан.Майдар эргэдэг байсан. Сүсэгтнүүд их ирнэ. Яг хэдийд эргэдэг байсныг нь санахгүй байна. Ид л зун эргэдэг байсан. Ганжуур эргэнэ. Ганжуурыг намар эргэдэг байсан. Хийдийн гадна талаар горооны чулуун замтай байсан. Тэр замаараа явж эргэнэ. Ловон, гэсгүй нар нь бүрээ бишгүүрээ бариад, лам нар, сүсэгтнүүд нийтдээ судраа тэврээд эргэдэг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хайлантай. 45 хоног үргэлжилдэг байсан. Намрын адаг сард болдог байсан байх. Хайлангийн үед их л сэрүүн болчдог байсан санагдах юм. Хайланд гэлэн, гэцэл сахилтай 100 гаруй лам нар суудаг байсан. Нүгнээ сахина. Тогтмол сар бүрийн 15-нд нүгнээ сахина. Би тэр нүгнээнд томчуудыг дагаж гайгүй сайн суусан.

Хийдийн туурь тод байна лээ. Их сайхан газар байсан юм аа. Гурван талд нь үнс хогоо асгасан 3 овгор бий. Нутгийнхан одоо тэр үлдсэн овгоруудыг Гурван сайхан гэж нэрлэдэг болсон байна лээ.

Дуган бүр тусдаа жастай байсан. Харин Чойрт жас байгаагүй. Их жас буюу Цогчэн жастайгаа нэг байсан. Цогчэн жас хамгийн баян.

Лам нар нь хийдээ тойроод энд тэндгүй л байсан. Аймаглан суудаггүй байсан. Хийдэд зодоч лам нар байсан. Дондов, Гүндэй, Лувсангомбо зэрэг хүмүүс байсан. Сүүлийн үедээ тэднийг дагалдаад нэлээн хэдэн залуучууд явж байгаа л дуулддаг байсан. Гэхдээ тийм сүрхий сайн ч болж чадаагүй тарсан байх аа. Хандмаа нар байгаагүй. Манай Баруун хүрээнд ч байгаагүй. Ер нь тэр хандмаа нар чинь Хүрээнд л байсан дуулддаг.

Тэр үед одоотой ч адил аврал гүрэм ийм их байгаагүй юм. Хааяа хааяа үхэл зовлон тохиолдоход сахиус хуруулж байгаа гэж л байдаг байсан. Өвчин зовлонтой хүнд Буман дарь эх хуруулж байгаа гэдэг л байсан. Одоотой адил ингээд үргэлжилсэн юм байгаагүй юм. Манай тэнд зунд нь говь талынхан дээшээ нүүгээд гараад ирнэ. Тэгээд айраг цагаа, цагаан идээгээр ном их хуруулдаг байсан юм. Дарь эх, Манла их хуруулдаг байсан юм. Лам нар зунд мах идэхгүй. Яахав жаахан борц бол хийнэ.

Юндэн наймааных гэж нэг жижиг худалдааны газар байсан. Тийм ч их бараа таваартай байгаагүй. Харин Самбуу наймааных гэж Баруун хүрээнд дээр том пүүс байсан юм. Манай тэнд байсан Юндэн наймааных бол Баруун хүрээний салбар нь байсан юм шиг байгаа юм.

Лам нар баригдаад, хамгийн сүүлд, хавар бүгдийг нь ачаад ачаад аваад явчихсан. Хоёр гурван машинаар, 2, 3 дахин ирж авсан юм шүү.

Манайхаас хамгийн түрүүнд Сүнрэв гавж, Дашчийрэв гавж хоёрыг маргааш шинийн нэгэн гэж байхад битүүний өдөр, 1937 онд барьж аваад явчихсан. Сүүлд нь хаврын дунд сарын үед хоёр гурав дахиж барьж аваачсан. Тэр үед лам нарыг дээд анги, дунд анги, доод анги гэж гурав хуваасан. Дээд ангид нь дан миндагтан лам нар байсан. Дээд ангийг тэр чигээр нь цаазалсан. Ерөөсөө үлдээгээгүй. Дунд ангиас ч бас хүн хэлмэгдсэн юм шүү. Гэхдээ цөөхөн. Доод анги бол бид. Миний хувьд хар болж мал дээр гарсан. Тэгээд намар нь сумын бүлгэмд сууж монгол бичигт тайлагдсан. Ингээд 1940 онд цэрэгт яваад 5 жил цэргийн алба хаасан. Цэргээс ирээд монгол бичигтэй, шинэ үсэгт тайлагдсан байсан болохоор аймгийн гүйцэтгэх захиргаанд санхүүд зааварлагч гэдэг ажил хийж байсан. Тэндээ нэг жил ажиллаад манай ар гэрт үхэл зовлон болоод хөдөө гарч мал малласан. Сумдаа багийн дарга зэрэг алба ажил хашиж байгаад 1961 онд хүүхдүүдээ дагаж аймгийн төвд орж ирсэн хүн дээ би. 1971 онд Улаанбаатар хотод орж ирсэн.

Арав гаран жил суусан юм болохоороо өөрийн хүслээр эргээд лам болсон доо. Манай зиндаанаас үлдсэн хүн одоо алга байна. Ёстой байхгүй болсон юм байна даа. Монголд шашин хөгжихөд хуучин уламжлалаа баримтлан хөгжөөсэй гэж бодож Эх болсон зургаан зүйл хамаг амьтан эрүүл энх байгаасай гэж залбирч байна

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

даа. Бидний үеийн дэг жаяг бол их нарийн чанд байлаа. Хуралд хурж байгаад бие засахаар боллоо гэхэд гэсгүйдээ гомбо айлтгаад л гарна. Одоо энэ мэтийн дэг журам ч үгүй байна.

Манай Зүүн хүрээ сэргээгдээгүй. Үлдсэн гар зураг, бурхан шүтээн ном судар үгүй байх аа. Бүгдийг нь шатаасан юм гэдэг. Аймгийн шашин хариуцсан Мөрдэлэг гэдэг хүн байсан. Тэр л 1938 оны намар Баруун хүрээн дээрээс баахан хоригдол дагуулаад арав гаран морин тэрэгтэй ирээд арав гаран хоног пэжигнэж, пэжигнэж шатаахыг нь шатаачихаад дуганыг нь онгорхой орхиод явсан гэдэг юм. Дуганын модыг аймаг руу зөөж мөн хүмүүс малын хашаа хороо барих зэргээр ашигласан байх.

Хийдийн ерөнхий байдал нь хойноо 6 суврагатай байсан. Суварганы баруун урд талд суварган жасын дуган, суварганы зүүн талд нүгнээ жасын дуган, нүгнээ жасын зүүн хойхнотой дүншигийн жас гэж байсан. Урагшлаад төвдөө Цогчэн дуган гэж нэлээн том дуган байсан. Цогчэн дуганын хойно сахиусны дуган байсан. Цогчэн дуганын баруун талд Манлын, зүүн талд чойрын дуган, баруун урд талд хайлан жас байсан. Хайлан жасын баруун урд талд нь Ламын чодвын дуган байсан.